

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААН



### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-15
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	16-40
1. “Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	16-37
2. “Коронавируст халдварын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн зарцуулалт, гадаадын орнудаас авсан зээл, тусламж, дотоодын иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж, тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	37-40

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 06 дугаар сарын 27-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Т.Доржханд, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар;

Чөлөөтэй: Ж.Ганбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Цэрэнпунцаг, Д.Батлут.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл үг хэлэв.

**Нэг. “Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны Хяналт зохицуулалтын албаны дарга П.Ганболд, Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга Н.Батсайхан, мөн төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер З.Туяа, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, референт А.Хонгорзул, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нар хариулж, тайлбар хийв.

Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.1.“Монгол Улсын агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших агаар мандлын орон зайг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.5.“агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах төхөөрөмжийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.8.“аэродром” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулан тоногдсон газар, талбай, усан гадаргууг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.14.“нисэхийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа, түүнд хамаарах нисэхийн бусад үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хадгалах тогтолцоог;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.17.“иргэний нисэхийн үйл ажиллагаа” гэж иргэний агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбоотой цогц ажиллагааг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.12 дахь заалтын “болон түүнд хамаарах бусад” гэснийг “, түүнд шууд дэмжлэг үзүүлэх бусад” гэж, “гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг” гэснийг “гүйцэтгэхийг” гэж, 5.1.15 дахь заалтын “хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар” гэснийг “иргэний нисэхийг” гэж, 5.1.16 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “шаардлагатай гэж үзвэл гадаад улсын” гэснийг хасаж, “тухайн” гэснийг “гадаад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.12 дахь заалтын “навигацийн” гэсний дараа “болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ олгох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.4.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “стандарт, журмын” гэснийг “стандартын” гэж, 9.2.5 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж өөрчилж, 9.2.5 дахь заалтын “зөвшөөрөл,” гэсний дараа “агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “тухайн салбарт 15-аас доошгүй жил ажилласан” гэснийг хасаж, “тавих шаардлагыг хангасан, Монгол Улсын иргэн” гэснийг “тавигдах шаардлага хангасан” гэж, 10.2.10 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг “иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу” гэж өөрчилж, 10.2 дахь хэсгийн “дараахь” гэсний өмнө “Засгийн газрын агентлагийн эрх зүйн айдлын тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна” гэж, 10.2.5 дахь заалтын “мэдээлэх” гэсний өмнө “мэдээллийг хийсний өмнө холбогдох этгээдэд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ж.Бат-Эрдэнэ, С.Чинзориг, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээнд” гэснийг “Конвенцын хавсралтад” гэж, 12.1.1 дэх заалтын “тайлбар” гэснийг “тайлбарыг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

батлах” гэж, 12.1.6 дахь заалтын “дүрэм” гэснийг “шаардлага тогтоох” гэж, 12.1.7 дахь заалтын “тогтолцооны нийтлэг зохицуулалт” гэснийг “тогтолцоог хэрэгжүүлэх” гэж, 12.1.17 дахь заалтын “хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “хөлгөөр сонирхогчийн үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж тус тус өөрчилж, 12.1.8 дахь заалтын “хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон” гэснийг, 12.1.11 дэх заалтын “том, дунд, жижиг оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.19 дэх заалт, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалтын “аргачлал” гэснийг хасаж, 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Иргэний нисэхийн дараах үйл ажиллагааг эдийн засгийн зохицуулалтын дүрмээр зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.5.Энэ хуулийн 14.1, 15.2 дахь хэсэгт хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг болон агаарын хөлгийн загварын нислэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Томилогдсон гадаадын” гэснийг “Гадаад улсын эрх бүхий байгууллагаас томилогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11



2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төсөлд доор дурдсан агуулгатай 19 дүгээр зүйл нэмэх:

**“19 дүгээр зүйл.Иргэний агаарын хөлгийн баг**

19.1.Иргэний агаарын хөлгийн баг нь нисгэгч болон багийн бусад гишүүдээс бүрдэнэ.

19.2.Нислэгийн үед нислэгтэй холбогдох үйл ажиллагаа явуулах нисгэгчээс бусад ажилтнууд агаарын хөлгийн багийн бусад гишүүнд хамаарна.

19.3.Монгол Улсын иргэний агаарын хөлгийн багийн бүрэлдэхүүнд гадаад улсын иргэн байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

20.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 17 дугаар зүйл болгох.

**“17 дугаар зүйл.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа**

17.1.Ерөнхий зориулалтын нислэгт хувийн болон чөлөөт, хөнгөн, хэт хөнгөн, хүнгүй агаарын хөлгөөр гүйцэтгэх, хэт хөнгөн агаарын хөлгөөр гүйцэтгэх сонирхогчийн нислэг болон тэдгээрт хамаарах бусад нислэг багтана.

17.2.Ерөнхий зориулалтын нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлгийн өмчлөгч, эзэмшигч хариуцна.

17.3.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааг иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

17.4.Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаанд иргэний нисэхийн дүрэмд зааснаас бусад хязгаарлалт тогтоохыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь хэсгийн “гэрчилгээ нь хүчингүй болсон” гэснийг “гэрчилгээгүй” гэж, 22.1.7 дахь заалтын “агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нисгэх багийн” гэснийг “нисгэгчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “Чикагогийн конвенцын 25 дугаар зүйлийн дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар хэсэг нэмэх.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

“Тайлбар: Энэ зүйлд заасан “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж Улсын нисэхийн тухай хуулийн 4.1.1-д заасныг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 хэсгийн “стандарт, журмын” гэснийг, “стандартын” гэж өөрчилж, 27.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.3.Конвенцын хавсралтад заасан стандартын шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглан хяналттай агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, С.Чинзориг, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төслийн 28 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 7  
Бүгд: 11  
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

27.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “төрийн өмчит” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.3 дахь хэсэг нэмэх:

“33.3.Олон улсын нисэх буудал дахь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын “аэродромд нисгэх” гэснийг “аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн” гэж өөрчилж, 34.1.2 дахь заалтын “өндөржүүлсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “хяналтын” гэснийг “хяналт тавих мэргэжлийн” гэж, “7-гоос” гэснийг “таваас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “анхан шатны мэдээллийг нэн даруй, боломжит хэлбэрээр өгөх, дэлгэрэнгүй мэдээллийг” гэснийг “анхан шатны болон дэлгэрэнгүй мэдээллийг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад” гэж өөрчилж, 39.3 дахь хэсгийн “эзэмшигч” гэсний өмнө “өмчлөгч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “шалгагч шинжлэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Төслийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“51.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Найруулгын санал:**

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3 дахь заалтын “, эсхүл” гэснийг “болон” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зүйлийн 8.1.1 дэх заалтын “төрийн бодлого” гэснийг “талаар төрөөс баримтлах бодлого” гэж, 8.1.9, 8.1.10 дахь заалтын “албаны” гэснийг “байгууллагын” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “Конвенц, түүний” гэснийг “Конвенцын” гэж, 9.2.2 дахь заалтын “тохилогч” гэснийг “тохиролцогч” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь хэсгийн “нөлөөлөхүйц” гэснийг “нөлөөлж болзошгүй” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “үзлэг” гэснийг “хяналт” гэж, “иргэний нисэхийн мэргэшсэн” гэснийг “нисэхийн гэрчилгээжсэн” гэж, 11.3 дахь хэсгийн “шилжүүлэн гүйцэтгүүлэх” гэснийг “шилжүүлэх” гэж, 12.1.8 дахь заалтын “эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг “эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.9 дэх заалтын “хамгаалалтын хөтөлбөр” гэснийг “хамгаалалт” гэж, 12.1.12 дахь заалтын “ажиллагааны гэрчилгээжүүлэлт” гэснийг “ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.13 дахь заалтын “болон аэродромын үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт” гэснийг “, аэродромыг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.10, 12.1.14, 12.1.15, 12.1.16, 12.1.18 дахь заалтын “байгууллагын гэрчилгээжүүлэлт” гэснийг “байгууллагыг гэрчилгээжүүлэх” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын “үр шим” гэснийг “үр ашиг” гэж, 16.1.2 дахь заалтын “ажил гэдэгт” гэснийг “ажилд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь” гэснийг “Агаарын тээвэрлэгч” гэж, “гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээ бүхий” гэснийг “гүйцэтгэх шаардлага хангасан” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1.7, 22.1.8 дахь заалтын “нисгэх” гэснийг “агаарын хөлгийн” гэж, 19.3.2 дахь заалтын “өөрөөр шийдвэрлэх” гэснийг “нислэгийг хэвийн үргэлжлүүлэх” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “нислэгийн” гэснийг “нисэхийн” гэж, 20.5 дахь хэсгийн “дүрмээс гадуур” гэснийг “дүрэмд зааснаас бусад” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “зорчигчийг аюулгүй болгох” гэснийг “зорчигчид шаардлага тавьж, аюулгүй байдлыг хангах” гэж, 21.4 дэх хэсгийн “учруулахуйц” гэснийг “учруулж болзошгүй,” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтын “гэрчилгээ нь хүчингүй болсон” гэснийг “гэрчилгээгүй” гэж, “зөрчсөн” гэснийг “зөрчиж” гэж, 22.1.6 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж, 22.1.7 дахь заалтын “нисгэх” гэснийг “нисэх” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “нэвтрэн өнгөрөх” гэснийг “нэвтрэх” гэж, 23.2 дахь хэсгийн “Нислэгийн хөдөлгөөний” гэснийг “Агаарын навигацийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэрт” гэснийг “нутаг дэвсгэр, агаарын зайд” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “зайн” гэснийг “зайд” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “байгуулна” гэснийг “байгуулж болно” гэж, 29.3 дахь хэсгийн “аэродром нь” гэснийг “аэродромын үйл ажиллагаа эрхлэгч” гэж, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн “хууль, дүрмийг” гэснийг “хууль тогтоомж, иргэний нисэхийн дүрмийг” гэж, 33.4 дэх хэсгийн “хураан авах, эсхүл саатуулна” гэснийг “хураан авна” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж, “гэрчилгээжүүлэлт” гэснийг “гэрчилгээ” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.3 дахь заалтын “үзлэг” гэснийг “хяналт” гэж, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “нислэг техникийн” гэснийг “агаарын хөлгийн” гэж, 42 дугаар зүйлийн 42.4.6 дахь заалтын “албаны” гэснийг “байгууллагын” гэж, 45 дугаар зүйлийн 45.1, 45.2 дахь хэсгийн “алба” гэснийг “байгууллага” гэж тус тус, “төрийн захиргааны байгууллага” гэснийг “иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тохиолдол бүрд өөрчилж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “үйлдэж байгаа” гэснийг дараах “улсын агаарын хөлгийн” гэснийг мөн заалтын “бусад” гэснийг дараа шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “, тэдгээрийг багтаасан” гэснийг, 5.1.7 дахь заалтын “эсхүл” гэснийг, 5.1.8 дахь заалтын “Чикагогийн” гэснийг, 5.1.10 дахь заалтын “, түүний” гэснийг, 5.1.13 дахь заалтын “төлөв” гэснийг, 5.1.18 дахь заалтын “Чикагогийн” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “үйл” гэснийг, 9.2.5 дахь заалтын “иргэний” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “эсхүл” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “агаарын хөлөг үйлдвэрлэгчийн” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “нислэгийн үйл ажиллагаанд” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “агаарын хөлөг” гэснийг, 23.2 дахь хэсгийн “нисгэх” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “дарга, нисгэх” гэснийг, 43 дугаар зүйлийн 43.2.1, 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “ямар ч үед” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 9 дүгээр зүйлийн “хэлэлцэн” гэсний өмнө “Конвенцын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтын “Дарга” гэсний дараа “энэ хуулийн 11.1-д заасан” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “зохицуулалт” гэсний дараа “хийх” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “гэрчилгээ” гэсний өмнө “агаарын тээвэрлэгчийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “Нислэгийн” гэсний дараа “үед” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “багийн” гэсний өмнө “агаарын хөлгийн” гэж, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “зориулсан” гэсний дараах “аэродромын” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний дараа “/цаашид “Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага” гэх/” гэж, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хамгаалалтын” гэсний дараа “үйлчилгээний” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “нислэгт” гэсний өмнө “агаарын хөлгийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*“Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “4 дүгээр зүйлийн” гэсний дараа “4.1.1 дэх заалтын “дээших хийн мандлын агаарын давхаргын” гэснийг “дээших агаар мандлын” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэв.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Коронавируст халдварын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн зарцуулалт, гадаадын орнуудаас авсан зээл, тусламж, дотоодын иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж, тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл нар хариулж, тайлбар хийв.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхий хяналтын сонсгол явуулах, бэлтгэл ажил хангах ажлын хэсгийг байгуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Ж.Батсуурь, Б.Баттөмөр, Г.Тэмүүлэн, М.Оюунчимэг нарыг томилж, ажиллуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэлийг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5



2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Коронавируст халдварын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн зарцуулалт, гадаадын орнуудаас авсан зээл, тусламж, дотоодын иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж, тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох асуудлаар ерөнхий хяналтын сонгогч явуулах товыг 2023 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 55 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 07 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон  
“Их эзэн Чингис хаан” танхим  
15 цаг 12 минут.

**БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцогч гишүүдийг танилцуулъя.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Наянтайн Ганибал гишүүн ирсэн. Хассуурийн Ганхуяг гишүүн ирсэн. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн ирсэн. Чинбатын Ундрэм гишүүн ирсэн. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн. Содномын Чинзориг гишүүн ирсэн. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн. Төмөртоогогийн Энхтүвшин ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 55,6 хувьтай болсон тул 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хурлыг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд.

2 дахь нь бусад асуудал гэсэн 2 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Хэлэлцэх асуудлын бусад дээр нэг санал байгаа. Улсын Их Хурлын даргын зөвлөл дээр бас яригдсан Ардчилсан намын бүлгээс Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу ерөнхий хяналтын сонсгол хийх ийм хүсэлт хүргүүлсэн. Энэ асуудлыг даргын зөвлөл дээр бас ярилцсан. Тэгээд материалын ингээд бүрдэл хангагдсан тул бусад гэдэгт энэ сонсголыг товлох ажлын хэсэг байгуулах асуудлыг хэлэлцэж өгнө үү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Бусад гэдэг тэгвэл нээлттэй сонсгол байгаа. Нээлттэй сонсгол явуулах ерөнхий хяналтын сонсгол явуулах тов тогтоох асуудлыг оруулъя. Ингээд 2 асуудал хэлэлцье.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслөөр анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлбэ.**

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг миний бие танилцуулъя.

Ингээд Ажлын дэд хэсгийг урьж байна.

Танилцуулга. Монгол Улсын Засгийн газар 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооноос төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчийн шийдвэрээр хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг Улсын Их Хурлын Тамгын газар, Зам, тээврийн хөгжлийн яам, ИНЕГ, Иргэний нисэхийн үндэсний төвийн төлөөллийг оролцуулан байгууллаа.

Ажлын хэсэг 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж, төслийн анхны хэлэлцүүлгийг бэлтгэлээ. Ажлын хэсэг Иргэний нисэхийн тухай хуулийн төслийн талаар 35 зарчмын зөрөөтэй саналын томьёолол, 3 найруулгын саналын томьёолол, хамт өргөн мэдүүлсэн Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн төслийн талаарх 1 зарчмын зөрөөтэй саналын томьёолол бэлтгэн Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Зарчмын зөрөөтэй саналын томьёолол нь агуулгын хувьд дараах хүрээг хамарч байна.

1.Агаарын зай, агаарын хөлөг, аэродром, нисэхийн аюулгүй байдал, иргэний нисэхийн үйл ажиллагаа зэрэг зарим нэр томьёоны тодорхойлолтод өөрчлөлт оруулах

2.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын даргад тавигдах шаардлагыг бусад хуульд нийцүүлэх

3.Иргэний нисэхийн дүрмийн талаарх зохицуулалтад өөрчлөлт оруулах

4.Нислэгийн үйл ажиллагааны төрөл түүнчлэн ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулах

5.Иргэний агаарын хөлгийн багийн талаарх зохицуулалтыг төсөлд нэмэх

6-д, хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг зэрэг зарим зохицуулалтад өөрчлөлт оруулах

7.Олон улсын нисэх буудал дахь нислэгийн нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчид хуулийн этгээд гүйцэтгэх

8.Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын зохицуулалттай төслийн зарим зүйл, заалтыг нийцүүлэх

9.Төслийн зүйл, хэсэг, заалтыг нийлүүлж өөрчлөх зэрэг хүрээнд зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг бэлтгэсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, ажлын хэсгээс боловсруулан оруулж байгаа зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэхийг та бүхнээс хүсье.

Ажлын дэд хэсгийг танилцуулъя.

Сандагдоржийн Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Доржийн Эрдэнэбат Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх, Чимэддоржийн Мөнхтуяа Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Сүхээгийн Мяндасмаа Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Пүрэвжавын Ганболд Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны дарга, Нямсамбуугийн Батсайхан Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга, Зинамэдэрийн Туяа Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа, хүний нөөцийн газрын менежер.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд байвал нэрээ өгнө үү. Цогтгэрэл, Энхбаяр гишүүнээр тасаллаа. Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Энэ Иргэний нисэхийн хуулийн энэ хэлэлцүүлэг явагдаж

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байна л даа. Үүн дээр нэлээн тийм аюулгүй байдал, захиргаа талын зүйлсүүд маш их харагдаж байна. Ер нь Монгол Улс чинь өөрөө өргөн уудам нутагтай, аймаг, сум, засаг захиргааны нэгжүүд бас их хол зайтай. Үүний цаана энэ хол зай гэдгийн цаана цаг хугацаа болоод эдийн засгийн ойлголт үүний цаана явж байгаа. Тэгэхээр ер нь энэ хуулийн үзэл баримтлал болоод зорилго чиглэлд ер нь иргэний нисэх гэдэг чинь энэ улс орон даяараа тэр хөнгөн онгоцууд, жижиг онгоцууд аймгууд руу, томоохон сумдууд руу нисэх зорилго мэдээж үүний цаана байгаа болов уу гэж бодож байна. Тэгэхээр одоо тийм нөхцөл бололцоо хангагдаагүй зөвхөн нэг аймгууд руу татаастайгаар зарим хөдөлгөөнүүд ингээд өнгөрсөн 7 сарын 01-нээс ч билүү зарим зүйлүүд тэгээд. Ер нь цаашдаа энэ нэг сумдын нислэг гэдэг зүйлийг энэ хуулийн үзэл санаа дээр яаж харж байгаа юм, ямар нөхцөл хангагдвал энэ рүү алхам хийгдэх юм. Эдийн засгийн болоод бусад талыг нь, дэд бүтцийг нь ямар нөхцөл хангагдвал бид нар энэ улс орон даяараа ийш тийшээгээ хурдан хугацаанд хүрч болдог энэ нөхцөл хангагдах юм. Одоо чинь ер нь яг эдийн засгийн утгаараа Монгол Улсад хүн аялах, жуулчлах, эдийн засгийн харилцаанд орох гэдэг зүйл бараг л байхгүйтэй адилхан ийм нөхцөл байдалд байгаа шүү дээ ер нь. Тэгэхээр үүн дээр энэ хуулийн үзэл санаа болоод энэ хуулийн зүйл заалтууд дээр үүнийг юу гэж харсан юм бол оо.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгээс хариулах уу? 4 дүгээр микрофон, 1 номер.

Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Эрдэнэбат Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Иргэний нисэхийн салбар маань одоо ч гэсэн мөрдөгдөж байгаа эрх зүйн зохицуулалтаараа дотоодын агаарын тээвэр дээр маш чөлөөтэй либерал маягаар явж байгаа. Ялангуяа орон нутгийн чиглэлд нисэх авиа компаниуд болон нисэх хүсэлтэй хүмүүсийн хувьд ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Чөлөөтэй либерал аль ч чиглэлд

хэдэн ч удаа нисэж болохоор ийм зохицуулалт мөрдөгдөж байгаа.

Таны хэлсэн тэр бага оврын болон хөнгөн агаарын хөлөг дээр мөн иргэний нисэхийн хяналттай бус агаарын зайд зөвхөн Нислэгийн төлөвлөлтийн албанд холбоогоор и-мэйлээр юм уу утсаар мэдэгдээд л жижиг онгоцтой хүмүүс ч юм уу дуртай газраа нисэх эрх нь бас нээлттэй байгаа. Энэ хуульд таны хэлсэн асуудлуудыг бас шинээр оруулж ирж байгаа нь хуульд иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалт гэдэг бүлэг шинээр нэмж оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл иргэний нисэхийн энэ орон нутгийн нислэг, олон улсын нислэг, ер нь либералчлах асуудлуудыг холбогдох эдийн засгийн зохицуулалтуудын дүрмээр зохицуулна гэдэг ийм асуудлуудыг шинээр оруулж ирж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цогтгэрэл гишүүн тодруулъя. Цогтгэрэл гишүүний микрофоныг нээе.

**О.Цогтгэрэл:** Үгүй ээ, яах вэ, зүгээр асуулт болохоор одоо чөлөөтэй байгаа ч гэсэн энэ дэд бүтцийн хувьд, нислэгийн хувьд, агаарын зайн хувьд энэ чинь бодит байдал дээр энэ нислэгүүд байхгүй байгааг бүгдээрээ л мэдэж байна л даа. Тэгэхээр энэ ямар нөхцөл хангагдвал энэ дэд бүтэц бий болох юм бол, үнэ үнэтэй байгаад ард иргэд энэ ард иргэдэд энэ нислэгийн үнэтэй байгаад байна уу? Яг юунаас болоод энэ одоо бодит байдал дээр энэ хэрэгжихгүй наад либерал байгаа зах зээл чинь өөрөө амилахгүй байгаа юм бэ л гэдэг л асуулт л асуух гээд байна л даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 номерын микрофон.

**Д.Эрдэнэбат:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Яг өнөөдрийн байдлаар ялангуяа орон нутгийн иргэдийн маань бас худалдан авах чадвар 1 дүгээрт бага

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байна, 2 дугаарт бас бид нар агаарын хөлгийн түлш ерөнхийдөө орон нутгийн нислэгийн нийт зардлын бараг 45-48 хувийг эзэлж байгаа. Энэ маань бас нэлээн зах зээлээс өндөр байгаа.

МИАТ компанийн хувьд нойтон түрээсийн онгоцоор нисэж эхэлж байгаа. Гэхдээ энэ дээр яах вэ, нойтон түрээс гэдэг асуудал зүгээр өөрийн онгоц авах 2-ын хоорондох зөрөөг нь л нэг удаадаа навигацийн орлогоос олгоё гэж байгаа. Түүнээс МИАТ компани өөрөө орон нутгийн онгоц авахаар гэрээгээ байгуулах гээд явж байна. Хэрвээ ингэсэн тохиолдолд ямар нэгэн татаас улсаас авахгүйгээр өөрсдөө ингээд яг бизнесийн зарчмаараа цаашаа нисээд явчихна.

Таны асуусан дэд бүтцийн хувьд Иргэний нисэх ерөнхий газраас хангалттай нислэг үйлдэх бүтцүүдийг орон нутагт бүрдүүлсэн байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсгийн ахлагчийн хувьд нэг бас жоохон тодруулчихъя. Ер нь иргэний нисэхийн либералчлал гэдэг зүйлийг нэлээн хэдэн жилийн өмнөөс эхлээд хийж байгаа. Аж ахуйн нэгжүүд өөрсдөө үйл ажиллагаа явуулах нислэгийн үйл ажиллагаа явуулах тал дээр нь нээлттэй боломжийг нь олгоод өгчихсөн байгаа. Гагцхүү зүгээр сая жоохон тодруулаад хэлэх хэрэгтэй байх. Энэ 7 сарын 01-нээс эхлээд татаастай ажиллаж байгаа нислэг хийнэ, тийм үү. 7 сарын 01-нээс хийж байгаа, энэ чинь татаастай байгаа. Тэгэхээр татаас гэдэг маань өөрөө эдийн засгийнхаа үр ашиг нь гарч өгөхгүй байгаа болохоор аж ахуйн нэгжүүд нисэх ийм боломж бололцоогүй байна л гэдгийг хэлэх гээд байгаа шүү дээ, зөв үү? Тийм болохоор татаас өгч байж 7 сарын 01-нээс эхлээд нисэж байна гэж би ойлгож байгаа. Энэ дээр бас нэг жоохон тодруулаад өгөөч, тийм.

1 номерын микрофон. Ашиггүй л гэсэн үг болж байна шүү дээ.

**Д.Эрдэнэбат:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ МИАТ компани энэ улсаас татаас авч нисэж байгаа нислэг бол 12 сарын 31-нээр дуусгавар болно. Энэ хугацаанд МИАТ компани өөрөө онгоцоо судалж байгаа. Ерөнхийдөө 2 онгоц судлаад энэ 2 дээрээ эквашаа сургана, инженерүүдээ сургана, ингээд 01 сарын 01 гэхэд бэлэн болоод өөрсдийнхөө онгоцоор нойтон түрээсийн биш өөрсдийнхөө онгоцоор нисэж эхэлнэ. Энд 01 сарын 01-нээс ямар нэгэн татаас өгөхгүй. МИАТ компанид.

**Ж.Бат-Эрдэнэ:** Онгоц шинээр авч байгаа юм уу?

**Д.Эрдэнэбат:** Тийм, шинээр судлаад үндсэндээ нэг и ар жи 170, и ар жи 175 гэдэг 2 онгоц сонгоод тэгээд ерөнхийдөө гэрээгээ байгуулах шатанд явж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Уучлаарай, би нөгөө ажлын хэсгийн гишүүн байгаа юм. Тэгээд уг нь асуух ёсгүй. Тэгээд сая нөгөө Хууль зүйн байнгын хороо өглөө 10-аас хуралдаад сая 3 цаг хүртэл хуралдаад дууссан. Тэгээд энэ хооронд бас ажлын хэсэг маань хуралдсан байгаа. Тэгээд цаг давхацсан учраас би нэг бас нэгэнт хууль учраас бас хууль маань хийдэл юм багатай гарах талаас нь бодож, нөгөө хэлэлцэх эсэх асуудлыг ишийдэж байх үед би нэг 2 асуулт асууж байсан юм. Жишээ нь, Монгол Улсын агаарын хилээр зөвшөөрөлгүй хил нэвтэрсэн агаарын хөлгийг албадаж билүү зэвсэг хэрэглэхгүй гэсэн байсан тийм ээ, нэг тийм заалт байсан. Би тэрийг хэлэлцэх эсэх дээр асууж байхад зэвсэгт хүчин бол түүгээрээ зэвсэг хэрэглэх эсэхээ ишийднэ ээ гэдэг хариулт авч байсан. Энэ маань яг биз дээ гэдгийг би нөгөө протоколд бас үлдээх ёстой. Яг энэ дээр орж ирэхдээ нөгөө үүний зэвсэгт хүчин нь хэрэглэнэ гэдгийг нь яг заагаагүй байсан. Зэвсэг хэрэглэхгүй гэхээр манай улсын агаарыг довтолгооноос хамгаалах анги,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нэгтгэлүүд тэр зөвшөөрөлгүй хил нэвтэрсэн, хариу дохио өгөхгүй байгаа, шаардлага биелүүлэхгүй байгаа агаарын хөлгийг өөрсдөө зэвсэг тэгээд яг хэрэглэх боломжтой болж дуусаж байна уу, боломжгүй болж дуусаж байна уу? Иргэний нисэхийг ойлгож байгаа. Иргэний нисэх чинь угаасаа зэвсэг байхгүй шүү дээ. Байхгүй юм чинь зэвсэг хэрэглэхгүй гээд бичээд яах вэ, тодотгож өгч байна лээ гэсэн үг.

Зэвсэг хэрэглэхгүй гээд ингэчихээр зэвсэгт хүчин зэвсэг хэрэглэхгүй болчих юм биш байгаа гэсэн юмыг би тодруулж протоколд үлдээх гэж байгаа.

2 дугаарт, асууж байсан нь би нөгөө агаарын нислэгийн үйл ажиллагаанд саад учруулсан иргэнийг таслан зогсооно билүү? Аюулгүй болгоно гэж нэг үг байсан тийм ээ? Тэгээд аюулгүй болгоно гэдэг нь багалж хүлэхийг ойлгож байна уу? Алж устгахыг ойлгож байна уу гэж би бас асууж байсан. Тэгэхээр надад багалж хүлнэ ээ гэж тухайн үед хариулж байсан. Өөрөөр хэлбэл амь насанд нь халдахгүй ээ, алахгүй ээ л гэсэн үг л дээ. Тэгээд 1 нөхөр онгоцны хаалгыг нь онгойлгох гээд байдаг, нөгөө нөхрийг чинь таслан зогсоох гээд боож хүлнэ, тэгж байтал үхчихнэ, үхчих ч юм билүү яачих ч юм билээ одоо мэдэхгүй л байна л даа би бол. Тэгэхээр ийм нөгөө нөхцөл байдал дараа нь энэ чинь үр дагавар гардаг учраас би зүгээр протоколд тэмдэглүүлж байгаа юм. Тухайн үед асууж байсан энэ асуултууд хэлэлцүүлгийн шатад ямар нэг байдлаар хөндөгдсөн үү, тодотгол болж орж ирж байгаа юу гэсэн ийм 2 асуулт байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэр 2 заалт дээрээ ажлын хэсэг хариул даа. 3 номер, 3 номерын микрофон.

**Ч.Мөнхтуяа:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулиар агаарын зайн аюулгүйн хяналт, зөрчил гаргасан агаарын хөлгийн зохицуулалтыг цэргийн

мэргэжлийн удирдлагын дээд байгууллага хэрэгжүүлнэ ээ гээд заачихсан байгаа. Тийм учраас бид нар нөгөө энэ орсон заалтаасаа иргэний агаарын хөлгийн эсрэг зэвсэг хэрэглэхгүй ээ гэдэг нь манай хуулиар зохицуулагдахгүй юм байна гээд тэр хэсгийг нь хасчихсан байгаа.

Зөрчил гаргасан дэг журам зөрчсөн зорчигчийн хувьд одоо ер нь орчин үеийн чиг хандлагад нийцүүлээд тухайн агаарын хөлөг дотор аюулгүй байдлыг нь хангуулахаар энэ Эйр маршал гээд аюулгүй байдлын ажилтан явна. Тэр хүн болохоор хүний эрхэнд халдах, гав бороохой хэрэглэх ч юм уу тийм нөхцөл байдалтай эрхтэй хүн байгаа. Гэхдээ агаарын хөлгийн багийн гишүүн нисэхийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй дэг журам зөрчсөн зорчигчийг номхруулах юм уу, аюулгүй болгох асуудлаар тэрийг нь бид хэд саяын хуульд байгаа заалтаар нь өөрчлөн найруулсан.

21.2 дугаар заалт дээр агаарын хөлгийн гишүүн, агаарын хөлгийн багийн гишүүн нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан, үйлдэл гаргахыг завдсан зорчигч, зорчигчид шаардлага тавьж аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна гээд үүнтэй холбоотой журмыг 21.3 дугаар заалтад хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, иргэний нисэхийн болон хууль зүйн асуудалд Засгийн газрын гишүүн хамтран батлахаар засаж оруулсан. Нөгөө аюулгүй болгоно гэдэг нь тодорхойгүй байсан учраас энэ журмаар зохицуулахаар найруулж оруулсан байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энхбаяр гишүүн тодруулъя.

**Б.Энхбаяр:** Энэ нөгөө сая хэлсэнчлэн, хүний халдашгүй байдалд нэлээн бодитойгоор халдах харилцаа яваад байгаа юм. Агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг аюулгүй болгоно гэдэг чинь сая гав бороо хэрэглэх, маршал

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

болчхоод буутай явдаг шүү дээ. Тэгэхээр буудна гэсэн үг шүү дээ. Буудахаар чинь хүн үхнэ шүү дээ. Тэгэхээр энэ хүнийг үхэх үр дагаварт буюу амь насыг нь хороох Үндсэн хуульд заасан амьд явах эрхийг нь хязгаарлах ийм үр дагавар үүсгэж байгаа харилцааг сайдын журмаар зохицуулахгүй. Хүний үндсэн эрхэд гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлалт тавина гэсэн Үндсэн хуулийн зарчим байгаа юм. Амьд явах эрх бол хүний салиггүй эрх байгаа, 4 эрхийнх нь нэг нь. Тэгээд энэ зөрчлийг арилгах шаардлагатай юм байна гэж хэлж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Зорчигчийн аюулгүй болгох гэсэн ийм төслөөр бол ийм үг үсэгтэй орж ирсэн. Үүнийг найруулаад зорчигчид шаардлага тавьж аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна гэсэн байгаа шүү. Тэгэхээр аюулгүй байдлыг хангах арга хэмжээ гээд тэгэхээр дэг журмыг сахиулах талынхаа арга хэмжээнүүд болж хувирах байх. Тийм, түрүүн бас нэлээн хатуухан шиг орж ирсэн, зорчигчийг аюулгүй болгох гэгчихсэн байсан. Энэ дээр бас нэлээн анхаарал хандуулж наадхаа зас, тэгээд дүрэм журамтайгаа уялдуулаад зас гэсэн ийм юугаар засаад орж ирж байгаа юм.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд ажлын хэсгээс гарсан зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалт явуулъя.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.1. “Монгол Улсын агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших агаар мандлын орон зайг;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн

Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Энхбаяр. Цаашид ажлын хэсэг гэх, санал хураалт.

Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Энэ Монгол Улсын агаарын зай гэж нэр томъёоны тодорхойлолт байгаа. Энэ Монгол Улсын агаарын зай гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших агаар мандлын орон зайг хэлнэ ээ гэсэн нэр томъёоны тайлбар оруулах гэж байгаа. Тэгэхээр энэ дээр зарчмын хувьд дэмжээд, найруулгын хувьд нэг ийм 2 хувилбараар тодотгол хийхгүй бол болохгүй байна. Яагаад гэхээр Монгол Улсын нутаг дэвсгэр гэдэг ойлголтод өөрөө юу гэж ойлгогдож явдаг вэ гэхээр Монгол Улсын нутаг дэвсгэр газар, үүнээс гадна нөгөө гадаад улсад суугаа манай улсын дипломат төлөөлөгчийн газар, усан зам бүхий далбаат хөлөг онгоцууд Монгол Улсын нутаг дэвсгэр гэдэгт багтаж, хууль зүйн хувьд ойлгогддог. Тийм учраас Монгол Улсын нутаг дэвсгэрээс л дээших агаарын мандлыг хэлнэ ээ гээд бид явчихаар гадаад улсын суугаа манай дипломат төлөөлөгчийн газрын дээдэх нь бас манай Монгол Улсын агаарын зай ч юм шиг болохоор ойлголт гарч болзошгүй учраас нэг тайлбар нэмээд, энд заасан Монгол Улсын нутаг дэвсгэр гэдэгт гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсын төрийн далбаа бүхий юу гэдэг билээ? Усан онгоц гэдэг билүү, хөлөг онгоц. Өөр энд ч юу ордог билээ, агаарын хөлөг өөрөө ордог юм шүү дээ, бас. Монгол Улсын төрийн далбаатай агаарын хөлөг чинь Монгол Улсын нутаг дэвсгэр болж явдаг байхгүй юу. Тэгэхээр тэр энэ 3 бол хамаарахгүй, одоо яг манай Монгол Улсын газар нутаг орно оо гэдэг санаа байхгүй юу. Ер нь бол санаа нь. Миний санаа ойлгогдож байна уу? Ойлгогдохгүй байна уу.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ойлгож байна, ойлгож байна.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Б.Энхбаяр:** Тийм, тийм санаагаар эсвэл протоколд тэмдэглэдэг юм уу.

**Ж.Бат-Эрдэнэ:** Протоколд тэмдэглэе, протоколд тэмдэглэе.

Санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.5. “агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтоож, хөдөлгөөн хийж чадах төхөөрөмжийг;”. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.8. “аэродром” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулан тоногдсон газар, талбай, усан гадаргууг;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.14 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.14. “нисэхийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа, түүнд хамаарах нисэхийн бусад үйл ажиллагааны эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хадгалах тогтолцоог;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.17. “иргэний нисэхийн үйл ажиллагаа” гэж иргэний агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбогдсон цогц ойлголтыг;”

Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Энэ нэр томъёоны тайлбар нэг л уншигдаж өгөхгүй байх шиг байх юм. Энэ төсөл нь, төсөл дээр чинь байхгүй байна. Орж ирсэн төсөл дээрээ. Иргэний нисэхийн үйл ажиллагаа гэж иргэний агаарын хөлгөөр үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой цогц ойлголтыг гээд энэ нэг л уншигдахгүй байна. Ингэж уншигдаад байгаа байхгүй юу. Иргэний нисэхийн үйл ажиллагаа гэж цогц ойлголтыг хэлнэ гэж. Үйл ажиллагаа гэдэг үг нь өөрөө процесс, материал одоо нөгөө материаллаг үг биш процесслог үг байхгүй юу. Үйл ажиллагаа гэдэг үг нь хөдөлж байдаг үг. Одоо нохой, гахай гэдэг шиг материаллаг зүйл биш процессыг илэрхийлсэн үг байхгүй юу. Энэ үгээ тайлбарлахдаа цогц ойлголт гэж нэр томъёогоор тайлбарлаад байна л даа. Хэрвээ үйл ажиллагаа гэдгийг тайлбарлах гэж байгаа бол энэ бол үйл явц юм эд нар гэж тайлбарлах гэж байгаа юм. Нэр томъёоны хувьд. Би ер нь ийм цогц ойлголтыг хэлнэ гэсэн ийм нэр томъёоны тайлбар сайн, энэ бусад хуульд байна уу, та хэд шүүж үзээч? Хуулиудаас. Ийм процессын шинжтэй үйл ажиллагааг цогц ойлголт гэж тайлбарласан ийм нэр томъёоны тайлбар би ерөөсөө мэдэхгүй, энэ нэг болохгүй байгаад байна шүү дээ. Одоо алхах гэдэг бол тэгээд энэ ингээд байгаа байхгүй юу. Агаарын хөлгөөр үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой цогц ойлголт гээд байгаа. Үйл ажиллагаа гэдэг бол үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой цогц ойлголт гэж тайлбарлаад байгаа байхгүй юу. Энэ хэл зүйн хувьд ерөөсөө уншигдахгүй байгаад байх юм.



2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Иргэний нисэх гэдэг гэж цогц ажиллагааг харин тийм, нэг ийм цогц ажиллагааг тийм ажиллагаа гээд энэ ийм процессоор тайлбарлагдах гээд байгаа байхгүй юу. Ойлголт биш энэ, ямар ч байсан. Цогц ажиллагааг гэх юм уу.

**Ж.Бат-Эрдэнэ:** Цогц ажиллагааг

**Б.Энхбаяр:** Тийм байна, тийм байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Харин тийм байна. Найруулгаар авчихъя, үүнийг.

5.1.17 дахиад уншъя. 5.1.17 Иргэний нисэхийн үйл ажиллагаа гэж иргэний агаарын хөлгөөр үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой цогц ажиллагааг. Санал хураалт, найруулгаар авчихъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.12 дахь заалтын “болон түүнд хамаарах бусад” гэснийг “, түүнд шууд дэмжлэг үзүүлэх бусад” гэж, “гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг” гэснийг “гүйцэтгэхийг” гэж, 5.1.15 дахь заалтын “хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар” гэснийг “иргэний нисэхийг” гэж, 5.1.16 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Ганибал гишүүн ээ, таны юм чинь орсонгүй, та сая хараад байсан чинь яасан. Ганибал гишүүний микрофоныг өгье.

**Н.Ганибал:** Ингээд төхөөрөмж ажиллаагүй учраас дахиад санал хурааж өгнө үү.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ, биш ээ, хүчингүй боллоо. Санал хураалт, дахин санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “шаардлагатай гэж үзвэл гадаад улсын” гэснийг хасаж, “тухайн” гэснийг “гадаад” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.12 дахь заалтын “навигацийн” гэсний дараа “болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ олгох” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.4.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “стандарт, журмын” гэснийг “стандартын” гэж, 9.2.5 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж өөрчилж, 9.2.5 дахь заалтын “зөвшөөрөл,” гэсний дараа “агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гэрчилгээ,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Ганибал гишүүн таны наадах чинь юу чинь ажиллахгүй байна уу? Яагаад байна? Ганибал гишүүний микрофоныг өгье.

**Н.Ганибал:** Төхөөрөмж дараад дараад болсонгүй ээ. Тэгэхээр дахиж санал хураалгаж өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё. Санал хураалт.

Энэ дээр нэг наадах чинь яагаад байна? Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё. Миний бас юун дээр сая анхаарал хандуулж юу яасангүй. Дахин санал хураалт.

54,5 хувиар саяын санал хураалт хүчингүйд тооцлоо. 11 дүгээр зүйлийн санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

12. Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 15-аас гэснийг 12-оос гэж, тавих шаардлагыг хангасан, Монгол Улсын иргэн гэснийг тавигдах шаардлагыг хангасан гэж, 10.2.10 дахь заалтын энэ хуульд заасны дагуу гэснийг иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу гэж өөрчилж, 10.2 дахь хэсгийн дараах гэсний өмнө Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна гэж, 10.2.5 дахь заалтын мэдээлэх гэсний өмнө холбогдох этгээдэд гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад тавигдах шаардлага дээр иргэний нисэхийн байгууллагад 15 жилээс доошгүй ажилласан байх гэдэг шаардлага хуулийн төслөөр орж ирснийг 12 жилээс гэж багасгаж оруулж байгаа юм байна. Би яах вэ, иргэний нисэхийн байгууллагад юм

даа, ёстой тийм ээ, ёстой онцлог, хариуцлагатай салбар гэдгээр нь ойлгож дэмжихээс биш тухайлсан хуулиудаар хүнд зориулсан ийм шаардлага тавих зарчмын эсрэг байдаг. Тухайлбал, Шүүхийн шинжилгээний хууль дээр 15 жил шүүхийн шинжилгээний байгууллагад ажилласан гэдэг шаардлага орж ирснийг би бас чуулган дээр ярьж, үүнийг бууруулж байсан. Манай Үндсэн хуульд зааснаар хамгийн өндөр шаардлага тавигддаг Улсын дээд шүүхийн шүүгч гэхэд л 10 жил ажилласан байх байхгүй юу, мэргэжлээрээ. Манай Үндсэн хуульд байгаа шаардлага шүү. Үүнээс ингээд аваад явна гэдэг энэ дандаа хүнд тавигдчихсан шаардлага болоод явчихдаг. Тэгээд би шүүхийн шинжилгээний хуулийн энэ 15, 6 жил ажилласан гэдэг нь хэдэн хүнд яг энэ шаардлагыг хангаж байна гэсэн нэг, хоёрхон хүн байсан юм шүү дээ. Тэгээд сүүлдээ тэр шаардлагыг бичсэн хүн нь ч гэсэн өөрөө тодорхой болсон. Энэ юу гэсэн үг вэ гэхээр хуулийн нэг зарчим үндсэн зарчим байдаг байхгүй юу. Хууль гэдэг бол хэн нэгэнд тусгайлан давуу байдал олгох, эсхүл хууль хэн нэгний муу муухайг үзэх гэж гарах ёсгүй гэдэг нэг ийм зарчим байдаг юм. Мууг үзэх гэж эсвэл давуу байдал олгох гэж. Одоо хүнд зориулж гаргаж болохгүй гэсэн үг. Хэн нэгэн хүнд. Тэр утгаар нь ийм их өндөр шаардлагатай Төрийн албаны хуульд бүр байгаа шаардлагаас өндөр, шаардлагууд гэдэг дандаа цаана нь нэг хүн байдаг л даа. Манайх байна шүү дээ. Төрийн захиргааны тэргүүн түшмэл буюу төрийн албаны хамгийн өндөр дээд алба хашиж байгаа Төрийн нарийн бичгийн дарга нарт ч ийм шаардлага байхгүй, 12 жил. Үүнийг 50 хувийг нь хангасан байх ийм шаардлагууд байгаа шүү дээ. Би тэгээд үүнийг бол ёстой иргэний нисэх юм. Цаана нь маш их өндөр хариуцлага нарийн мэргэшил юм. Энэ мэргэшлийг эзэмших гэж маш өндөр өртөгтэй би боловсон хүчнээ сургадаг гэж ойлгож байгаа шүү дээ. Ер нь тэгэх ч учиртай байх. Нэг олон улсын стандарт учраас.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэр утгаараа ийм шаардлага тавьж байгаа, өндөр шаардлага тавьж байгаа юм байна гэж ойлгож, дэмжинэ. Гэхдээ байна шүү дээ. Хэрвээ яг 12 жил гэдэг нь хэн нэгнийг өрсөлдөгчөө намнах юм уу, өрсөлдөөнөөс шахах хуулиар бүр, хууль гаргаж байгаад ийм давуу байдал олгох гэж байгаа бол энэ зарчим буруу байна гэдэг зүйлийг л би хэлэх гэж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ дээр хариулт хэлээдэх үү, би. Энэ 15 жил гэж орж ирээд бид нар ерөнхийдөө бас нэг буцаж эргэж харъя гэсэн юм. Ерөнхийдөө өөрийн чинь хэлж байгаа наад үндэслэлийг ерөнхийдөө харсан. Тэгээд ингээд төрийн албанд 12-оос доошгүй жил түүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаал 6-аас доошгүй эд нар гээд төрийн албаны тушаалд тавигдах шаардлагаас бас л бид нар 15-ыг 12 болгож л авсан юм байгаа юм. Төрийн албаны тухай хуулийн 23.2.1 дээрээс 15 гэж байсныг 12 болгож буулгасан юм байгаа юм.

Чинзориг гишүүн.

**С.Чинзориг:** Би Энхбаяр гишүүнтэй ойролцоо санал хэлэх гээд л байгаа юм. Энэ Иргэний нисэхийн ерөнхий газар чинь агентлаг гэж явдаг биз дээ, агентлаг байх, тийм ээ, тийм. Тэгэхээр би агентлаг юм чинь яг салбарын харилцаагаар хуулиар үүнийг заах шаардлагагүй шүү дээ. Төрийнхөө албаны тэр агентлагийн даргын нийтлэг шаардлагаараа л явна биз дээ. Яг энэ салбарын хууль руу ийм юм оруулах юм, тэгээд наад чинь дараа нь бүх хууль руу ийм юм орно шүү дээ. Энэ бол би нэг их оновчгүй л гэж л бодож байна. Яг тэр даргад тавигдах шаардлага нь төрийн албаныхаа хуулиараа зохицуулна гээд. Яах вэ иргэний нисэх жаахан арай өөр онцлогтой онцлог салбар л даа. Тэрийг нь өөр тэр Төрийн албаны хууль дээр нэмэгдээд мэргэжил өөр одоо ямар нэмэлт тийм шаардлага байх ёстой юм. Тэрийг нь энд тавиад яг тэр ажилласан жилтэй холбоотой эд нар шаардлага нь

тэр төрийн албаныхаа хуулиар л явах ёстой шүү дээ. Ер нь төрийн алба энэ мерит зарчмаар явах ёстой гээд. Тэгээд бид нар энэ төрийн албаны хуулийг чинь нэлээн босгохыг нь илүү өндөрсгөөд улсад ажилласан жилийг нь 16 гээд, тэгээд эрхэлсэн түшмэлээр ажилласан бол хугацааг нь 12 ч билүү гээд нэлээн чанга хийсэн. Тэгээд энэ бас л чангадаж байна. Нөгөө тавих гэж байгаа сонирхож байгаа улсуудад бас шаардлагад нийцэхгүй байна гэж шулуухан хэлэхэд бас тийм юм ярьсаар ирж байгаад л хавар Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулаад, ажилласан жил тэр эрхэлсэн түшмэлд ажилласан байх хугацаа эд нар чинь бас бууруулсан шүү дээ. Тэгээд тэр төрийн албаныхаа тэр хуулиараа л явах нь зүйтэй. Ажилласан жил нь бол. Ерөнхий өөр яг нарийн мэргэжил шаардсан салбар учраас тэр нэмэлт шалгуур юм байх юм бол оруулаад ажилласан жилтэй холбоотой юмыг нь тэр төрийн албаныхаа хуулиар л явах л юутай. Тэгэхгүй тэгээд 1 салбар дээр бид нар ингээд яг янз янзаар авч үзэж болохгүй. Тэгээд яг тэр суурь харилцаа зохицуулж байгаа тэр Төрийн албаны хуулиар явах нь зүйтэй гэсэн би тийм саналтай. Ажилласан жилтэй холбоотой юм эндээс авчих хэрэгтэй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дэмжихгүй болохоор тэгнэ. Энэ ийм байгаа. Ер нь бол төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч байх юм. Энэ дарга нь. Юуны хяналтын эрх, үүрэг бол энэ яамнууддаа шилжсэн юм шүү дээ. Тэгээд тэр утгаараа энэ салбар дээр нисэхийн салбар дээр хяналтын улсын ерөнхий байцаагч нь төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга байхаар энэ хууль орж ирж байгаа юм. Ер нь зарчим бол урьд өмнө нь бас нэг иймэрхүү байдлаар явж байсан.

Энэ санал хэрвээ унавал 15-аас доошгүй жил ажилласан гэдэг маань үлдчих гээд байгаа юм. Тийм, бүр чанга

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

болно. 15-аас доошгүй гэж орж ирсэн юм л даа. Төрийн албаны тухай хуулиасаа 12 гэж байгаа биз дээ? Тэр 12 гэдгийг. 3 дугаар микрофон Батболд хариулах уу? 2 дугаар микрофон 2. Батболд тайлбар хэл дээ.

**С.Батболд:** Гишүүний асуултад хариулъя. Энэ 15 жил гэдгийг үзэж байгаад бид нар яг энэ Төрийн албаны тухай хуульд байгаа агентлагийн дарга бол төрийн албанд 12 жил, эрхэлсэн тэргүүн зэргийн түшмэл буюу дүйцэх нь агентлагийн дарга байж байгаа, 12 жил. Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан гэсэн ийм шаардлагын дагуу 15-ыг 12 болгосон байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгвэл ингэх үү? Ажлын хэсгийн хар даа. Ажлын хэсгийн даргын хувьд би төслийг дахиад уншаадахъя.

12. төслийн 10 дугаар зүйлийн 10.1 гэдэг хэсгээс тухан салбарт 15-аас доошгүй жил ажилласан гэснийг хасаж гээд гэснийг хасаж, тавих шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн гэснийг тавигдах шаардлагыг хангасан гэж, 10.2.10 дахь заалтын энэ хуульд заасны дагуу гэснийг иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу гэж өөрчилж, 10.2 дахь хэсгийн дараах гэсний өмнө Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна гэж, 10.2.5 дахь заалтын мэдээллийг хийсний өмнө холбогдох этгээдэд гэж нэмэх.

Тэгээд энэ дээр ажилласан жилийг хасаад санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энхтүвшин гишүүний микрофоныг нээе.

**Т.Энхтүвшин:** Кноп ажилласангүй ээ. Дахин санал хураалт явуулж өгөөч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саяын энэ санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя.

54,5 хувиар саяын энэ санал хураалт хүчингүй боллоо.

Дахин санал хураалт явуулъя.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

13. Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн Монгол Улсын олон улсын гэрээнд гэснийг Конвен төсвийн хавсралтад гэж, 12.1.1 дэх заалтын тайлбар гэснийг тайлбарыг батлах гэж 12.1.6 дахь заалтын дүрэм гэснийг шаардлага тогтоох гэж, 12.1.7 дахь заалтын тогтолцооны нийтлэг зохицуулалт гэснийг тогтолцоог хэрэгжүүлэх гэж, 12.1.17 дахь заалтын хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт гэснийг хөлгөөр сонирхогчдын үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх гэж тус тус өөрчилж, 12.1.8 дахь заалтын хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон гэснийг 12.1.11 дэх заалтын том, дунд, жижиг оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.19 дэх заалт 12.2. 12.3. 12.4 12.5 12.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

15. Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалтын “аргачлал” гэснийг хасаж, 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Иргэний нисэхийн дараах үйл ажиллагааг эдийн засгийн зохицуулалтын дүрмээр зохицуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

*Ийм шинэ бүлэг нээж байна. Орж байгаа. Ер нь конвенцод заасан энэ дүрмүүдэд заасан зүйлүүд байна.*

*54,5 хувиар санал дэмжигдлээ.*

*16. Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:*

*“15.5.Энэ хуулийн 14.1, 15.2 дахь хэсэгт хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг болон агаарын хөлгийн загварын нислэг хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.*

*54,5 хувиар санал дэмжигдлээ.*

*17. Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Томилогдсон гадаадын” гэснийг “Гадаад улсын эрх бүхий байгууллагаас томилогдсон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.*

*54,5 хувиар санал дэмжигдлээ.*

*18. Төсөлд доор дурдсан агуулгатай 19 дүгээр зүйл нэмэх:*

***“19 дүгээр зүйл.Иргэний агаарын хөлгийн баг***

*19.1.Иргэний агаарын хөлгийн баг нь нисгэгч болон багийн бусад гишүүдээс бүрдэнэ.*

*19.2.Нислэгийн үед нислэгтэй холбогдох үйл ажиллагаа явуулах нисгэгчээс бусад ажилтнууд агаарын хөлгийн багийн бусад гишүүнд хамаарна.*

*19.3.Монгол Улсын иргэний агаарын хөлгийн багийн бүрэлдэхүүнд гадаад улсын иргэн байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.*

*Ганибал гишүүний микрофоныг өгье.*

***Н.Ганибал:*** *Төхөөрөмж ажиллаагүй тул дахиж санал хурааж өгнө үү.*

***Ж.Бат-Эрдэнэ:*** *Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон санал хураалт явуулъя.*

*54,5 хувиар саяын санал хүчингүй боллоо. Санал хураалт, дахин санал хураалт.*

*54,5 хувийн санал дэмжигдлээ.*

*19. Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.*

*Үг Энхбаяр гишүүн. Санал хураалт зогсооё. Энхбаяр гишүүний микрофон.*

***Б.Энхбаяр:*** *Энэ хасах гэж байгаа 19.5 нь ийм л заалт байна л даа. Агаарын хөлгийн дарга хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор эмнэлгийн болон бусад яаралтай тусламж хүргэх нислэгийг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмээр зөрчин гүйцэтгэж болно. Үгүй ээ, энэ чинь 2 заалт байна уу? Энэ аль нь юм бол? Энд хасахаар бид санал хураах гээд байна шүү дээ. Агаарын хөлөгт аюул учирсан тохиолдолд агаарын хөлгийн дарга нь хүний амь насыг аврах боломжтой бүх арга хэмжээг авсан нөхцөлд агаарын хөлгийг орхиж болно гэж өөрчлөн найруулж байгаа юм уу, эсвэл энэ заалтыг хасах гээд байгаа юм болов уу.*

***Ж.Бат-Эрдэнэ:*** *19.5. Энэ ингэсэн юм. Агаарын хөлгийн дарга хүний амь нас, эд хөрөнгийн хамгаалах зорилгоор эмнэлгийн болон бусад яаралтай тусламж хүргэх нислэгийг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг биш ээ, дүрмийг зөрчин гүйцэтгэж болно гэж байна. Энэ дээр агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдлыг хангах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор агаарын хөлгийн багийн гишүүд болон бусад зорчигчид*

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шаардлага тавьж биелэлтийг хангуулах бөгөөд нислэгтэй холбоотой эцсийн шийдвэрийг гаргана гээд. Тэгээд энэ дотор агуулга нь байгаа гэж үзээд хасаж байгаа юм. Тийм, тийм.

Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

20. Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 17 дугаар зүйл болгох.

**“17 дугаар зүйл.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа**

17.1.Ерөнхий зориулалтын нислэгт хувийн болон чөлөөт, хөнгөн, хэт хөнгөн, хүнгүй агаарын хөлгөөр гүйцэтгэх, хэт хөнгөн агаарын хөлгөөр гүйцэтгэх сонирхогчийн нислэг болон тэдгээрт хамаарах бусад нислэг багтана.

17.2.Ерөнхий зориулалтын нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлгийн өмчлөгч, эзэмшигч хариуцна.

17.3.Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааг иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

17.4.Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаанд иргэний нисэхийн дүрэмд зааснаас бусад хязгаарлалт тогтоохыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Одоо энэ дотор хамаарч байгаа. Энэ ерөнхий зориулалтын нислэг гээд энэ дотор нөгөө жижиг бүх юмнууд чинь орж ирж байгаа. Жижиг нислэгүүд, хөнгөн тэргүүд

54,5 хувиар санал дэмжигдлээ.

21. Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь хэсгийн “гэрчилгээ нь хүчингүй болсон” гэснийг “гэрчилгээгүй” гэж, 22.1.7 дахь заалтын “агаарын хөлгийн

даргын зөвшөөрөлгүйгээр нисгэх багийн” гэснийг “нисгэгчийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22. Төслийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

23. Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “Чикагогийн конвенцын 25 дугаар зүйлийн дагуу” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

24. Төслийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар хэсэг нэмэх.

“Тайлбар: Энэ зүйлд заасан “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж Улсын нисэхийн тухай хуулийн 4.1.1-д заасныг ойлгоно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

25. Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 хэсгийн “стандарт, журмын” гэснийг “стандартын” гэж өөрчилж, 27.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

27.3 Конвенцын хавсралтад заасан стандартын шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглан хяналтын хяналттай агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалтыг хүчингүй болгоё, цуцалъя.

Чинзориг гишүүнд микрофоныг нь нээе.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**С.Чинзориг:** Энэ 27.3 дээр тэр конвенцын заасан стандарт шаардлага байгаа юм байлгүй дээ. Тэгээд бичвэр нь болж байгаа юм уу, үгүй юм уу. Энэ Энхбаяр эд нар уг нь харж л байгаа байх даа, эд нар. 27.3 дээр чинь конвенцын хавсралтад заасан стандартын шаардлагад нийцсэн гээд хэзээд байтлаа бид нар чинь үндэсний хууль, тэр конвенцын заалт гээд тэр конвенцын хавсралтад заасан эд нар гэж юм бичиж байсан юм гээд. Тэгээд ороод ирсэн л байх юм даа. Одоо сүүлдээ тэгээд яг конвенц нь хуулиа хуулаад тэгээд бүр хавсралтыг нь эд нар хуулаад л ордог л болох юм байх даа. Би л магадгүй энэ конвенцын хавсралтад заасан эд нар гэж конвенцын тэр заалтыг хэрэгжүүлнэ ээ гэсэн юм ордоггүй шүү дээ. Үгүй бол бичвэрээ өөрчлөх юм уу?

Ер нь бол Үндэсний Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенц гэрээндээ нийцүүлж л манайх хуулиа боловсруулах болохоос биш яг тэр конвенцыг хууль болгоод энэ конвенцод гэдэг юм уу, эсвэл нэг хавсралтыг нь заасан шаардлага биелүүлнэ гэдэг хууль ер нь бичдэггүй, ярьдаггүй дээ. Тэгээд үүнийг яах юм? Ингээд явах юм уу? Хавсралтад заасан гээд явах юм уу? Үгүй бол тэр стандартын шаардлагад нийцсэн навигацийн байгууламж гээд ингээд явах юм уу? Тэгэхгүй бол тэр конвенцын хавсралтад заасан эд нар гэж ингэж хууль мэдэхгүй, энэ манай нисэхийнхэн хийдэг юм болов уу? Би л магад мэдэхгүй л юм.

Манай олон улсын нэгдэж орсон гэрээ конвенц чинь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр л дагаж мөрдөнө өө гээд. Тэгээд тэр конвенц гэрээндээ л бид нар нийцүүлж хууль тогтоомжийг нь нийцүүлж боловсронгуй болгоод л явдаг шүү дээ. Тэгээд энэ дээрээс яг конвенцын заалтыг дагаж мөрдөнө гэдэг юм уу, үгүй бол тэр хавсралтад заасан юу муу гэж ингэж хууль бичдэггүй шүү дээ. Үүнийг яах юм бол? Энэ ажлын хэсгийн ахлагч.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ 5.1.10 дээр иргэний нисэхийн дүрэм гэж олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц гэснийг бид нар чинь конвенц гэгчихсэн юм. Цаашид конвенц гэх. Тэгээд хавсралтад заасан стандартын суурь түвшнийг хангах зорилгоор энэ хуульд нийцүүлэн гаргасан нисэхийн аюулгүй байдлыг зохицуулах баримт бичиг гээд. Иргэний нисэхийн дүрэмд заасан гэж болохгүй юм уу? Тэгвэл энэ зүгээр стандартын шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламж төхөөрөмж. 3 номер Мөнхтуяа. Мөнхтуяа.

**Ч.Мөнхтуяа:** Монгол Улс 1989 онд 1944 оны Чикагийн конвенцод нэгдэн орсон. Энэ болохоор манай иргэний нисэхийн үйл ажиллагааг зохицуулдаг Үндсэн конвенц. Ард нь зөндөө олон улсын гэрээ конвенц байгаа юм. Энэ Чикагийн конвенц болохоор 19 хавсралттай. Тэнд стандарт тогтоосон. Энэ хавсралт стандартыг бид дагаж мөрдөх үүрэгтэй. Хэрвээ тэр минум стандарт нь хүрэхгүй бол мэдэгдэх үүрэгтэй. Тэгж байж энэ олон улсад бид үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ стандартыг хангахын тулд иргэний нисэхийн дүрмээр зохицуулна гээд энэ 12 дугаар заалт байгаа. Тийм учраас конвенц, конвенцын хавсралтад заасан гээд конвенцынх нь хавсралтад заасан стандартыг л дагаж мөрдөх үүрэгтэй.

Тэгэхдээ хуулийн энэ 2 дугаар заалттай олон улсын гэрээний өөрөөр заасан дагаж мөрдөнө гээд ерөнхий заалт нь байгаа, бас.

**Ж.Бат-Эрдэнэ:** Жил болгон эко, 2 жилдээ нэг билүү эко-ийн шалгалт орж ирдэг шүү дээ. Тэр шалгалтаар энэ конвенцын шаардлагууд хангагдсан байх ёстой гээд нэлээн том том заалтууд ингээд тавьчихдаг юм. Тэгээд бид нөгөөдөх тэр удаагийнх нь шалгалтад л тэнцэж байж, тэгээд энэ бүх өнгөрөлтийн нислэг, бүх одоо үйлчилгээнүүд маань стандартын дагуу зөвшөөрөгдөөд явдаг юм л даа. Тэгээд тэр

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

утгаараа манайхан конвенц гэж оруулчихаад байна.

*Чинзориг гишүүн тодруулъя.*

**С.Чинзориг:** Үгүй ээ, үгүй. Монгол Улс чинь ганцхан зам тээвэр нэгдээд байгаа юм биш. Бүх л олон улсын энэ гэрээ конвенцод нэгдэн ордог шүү дээ. Тэгээд хэзээ ингээд тэр гэрээ олон улсын гэрээ конвенцоо нэгдэж орно оо гэдэг чинь бид нар хүлээн зөвшөөрөөд дагаж биелүүлнэ ээ. Биелүүлэх үүрэг хүлээж байгаа шүү дээ. Тэгээд хэзээ тэгээд хууль болгондоо тэр гэрээ конвенцынхоо үг үсгийг оруулаад хавсралтыг нь ингээд хуульчилж байсан юм бэ? Тэр конвенцод нэгдсэн л бол тэрийг бид нар дагах ёстой, биелүүлэх л үүрэгтэй, үүрэг хүлээж байгаа шүү дээ, тэр олон улсынхаа өмнө, НҮБ-ынхаа өмнө, олон улсынхаа байгууллагын өмнө. Тэрийгээ л хэрэгжүүлнэ. Тодорхой хэмжээгээр тэр конвенцыг хүлээн зөвшөөрөхгүй юу, зохицуулсан биелүүлэх үүргээ л бид нар хуулиар хүлээж байгаа болохоос биш яг тэр конвенцын хавсралтыг биелүүлнэ гэдэг чинь тийм юм хуульд бичдэггүй шүү дээ. Бид ч гэсэн олон улсын хөдөлмөрийн байгууллагын суурь 8 суурь конвенцод Монгол Улс Хөдөлмөрийн суурь конвенцод нэгдэж орсон. Тэгээд тэрийгээ биелүүлэх л үүрэг. Тэр үндэснийхээ хууль тогтоомжид тэр конвенцод заасан минимум стандарт ч юм уу, тэрийг л шаардлага хангасан хуулиа л бид нар хийх үүрэгтэй болохоос биш үгүй бол хялбарчилж байгаа тэр конвенцын хавсралтад заасан стандартыг хангана гээд. Тэгвэл тэр конвенцынхаа хавсралтыг тэгвэл энэ хуулийнхаа тэр шаардлага болгоод бичихгүй юу. Нэгэнт олон улсын олон улсын өмнө бид нар тэр шаардлагын чинь стандартыг чинь биелүүлнэ ээ гэдэг үүрэг аваад л тэр конвенцод нэгдэн орчихож байгаа шүү дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ Мөнхтуяа. Ийм юм байна шүү дээ.

**С.Чинзориг:** Үгүй бол наад бичвэрээ өөрчил л дөө.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ иргэний нисэхийн дүрэм гэж. Дүрэм чинь өөрөө конвенцын шаардлагыг хангасан баримт бичиг мөн тийм үү? Тийм болохоор иргэний нисэхийн дүрэмд заасан стандартын шаардлага хангасан гээд явчихад болж байна шүү дээ.

3 номер Мөнхтуяа.

**Ч.Мөнхтуяа:** Нэмэлт тайлбар өгье. Конвенцын 19 хавсралт нь өөрөө стандарт тогтоосон. Тэр стандартыг стандарт, шаардлага, зөвлөмж 3 янз байгаа. Стандартыг нь бид яах биелүүлэх үүрэгтэй, тэр стандартаа дүрмээрээ дамжуулж. Гэтэл бид тэр стандартыг бүрэн хэмжээнд биелүүлж чадахгүй бол ийм ийм нөхцөл шаардлагын улмаас бид биелүүлж чадахгүй байна гэдгээ мэдэгдэх үүрэгтэй. Энэ нөгөө тэр Чикагийн конвенцоор л яваад байгаа юм. Тэгээд дэлхийн 193 улсыг эгнээндээ багтаасан энэ Чикагийн конвенцын хэлэлцэн тохирогч улсууд болохоор иргэний нисэхийн дүрэм нь ижилхэн дугаарлалттай байдаг. Жишээлбэл, бид агаарын навигацийн үйлчилгээ 5 төрлийн үйлчилгээ үзүүлэхийн тулд 171-175 нь янзын ингээд нөгөө 171 дүгээр дүрмээр нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ гээд ингээд ийм нөгөө стандартчилагдчихсан байдаг учраас энэ бид үүнийг ингээд дүрэмдээ оруулахгүй бол болохгүй.

Энэ аудитын үзлэг шалгалт ирэхээрээ үндсэн энэ нисэхийнхээ хуульд энэ шаардлага чинь хаана байгаа юм бэ гээд нэг загвар хууль гаргачихсан, тэр загвар хуулийнхаа энэ энийг нь зөвлөмж болгоорой гээд. Тэгээд бид нар одоогийн хууль ч ийм, шинээр орж байгаа хууль ч гэсэн ийм. Конвенц нь өөрөө стандарт биш, конвенцынх нь хавсралтууд нь стандарт, шаардлага, зөвлөмж тавиад байгаа байхгүй юу. Үүнийг л бид нар ингэж оруулах гээд.



2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Ж.Бат-Эрдэнэ:** Навигацитай холбоотой асуудал гэж байгаа болохоор энэ яг стандартынхаа шаардлага энэ конвенцоо бас дурдах хэрэгтэй болчихоод байгаа байх л даа. Ер нь бол тэгж байж нөгөө нэг цаад шаардлагаа бид нар хангах ёстой болж байгаа байх.

Санал хураалт.

1 номер нэрээ хэлээрэй.

Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Конвенцын хавсралт маань өөрөө яг олон улсад ямар шаардлагыг хангасан бол энэ өнгөрөлтийн нислэг дээгүүрээ авах ч юм уу олон улсын нислэг үйлдэх боломжтой гэдгийг стандартыг нь тогтоож өгсөн байдаг. Монгол Улсын дүрэм бол энэ стандартыг Монголд хэрхэн хангуулахын тулд ямар хяналт, зохицуулалт, хэн хяналтыг нь хийх вэ, хэн яаж зохицуулах вэ гэдэг үйл ажиллагаагаа зохицуулсан ийм зохицуулалтын асуудал, өөрөө бас стандарт тогтоохгүй байгаа юм. Тэгэхээр ерөнхийдөө олон улсын бас загвар хууль дээр ч байна, олон улсын энэ тавигдаж байгаа шаардлага дээр яг тодорхой энэ хавсралтын буюу арай аэро навигацитай холбоотой хавсралтад заасан яг энэ стандартыг л хангах ёстой. Бид нар энэ стандартыг өнөөдрийн байгаагаар хуульд оруулах боломжгүй. Энэ чинь өөрөө бас нэг 2-3 жилд өөрчлөгдөөд техник тоноглол, технологи хөгжих тусам ингээд байнга өөрчлөгдөж явдаг стандарт болчихоод байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Шаардлагад нийцсэн гээд үг үсэг болж болно шүү дээ.

**Д.Эрдэнэбат:** Тэгэхээр бас ийм нэг асуудал гараад байгаа юм. Чинзориг гишүүн ээ, АНУ-ын стандарт өөрөө энэ конвенцын хавсралтаас өндөр бүр ингээд өөрсдийгөө бүр дээд зэргээр хангахад бүр ингээд өндөр тогтоочихдог. Тэгэхээр энэ экаугийн конвенцын яг хавсралтад заасан стандарт бол энэ шаардлагыг минимум

энэ шаардлагыг биелүүлсэн байхад танайх олон улсын нислэг үйлдэж болно. Танай дээгүүр онгоц нисэж өнгөрөхөд олон улсын шаардлагыг хангасан гэдгийг чинь бид нар баталгаажуулж байна л гэсэн үг байгаа юм л даа. Тэгэхээр олон улсын стандарт гэчихвэл тэгвэл бид нар Америкийнхыг дагах уу, энэ бусад орнуудынхыг дагах уу гээд өөрөө бас нэг тийм ойлгомжгүй байдал үүсгэх гээд байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ жишиг хууль гэж эд нарт бас цаанаасаа нөгөө экаугаас гарсан хууль байгаад байгаа юм. Тэгээд энэ хуульд нийцэж байж бид нар нөгөө нэг дээгүүр өнгөрөлт гээд бүх л зүйл дээрээ нөгөө шаардлагыг нь хангаж байж олон улсын хэмжээнд харилцах энэ үүд хаалга маань нээгдэж өгөх гээд байгаа юм. Тэгээд тэгэхгүй бол хурч ирээд л нөгөөдүүл чинь нэг дунд дүн тавьчихаад л яваад өгдөг. Тэгээд эндээс болоод манай нөгөө иргэний агаарын тээврүүдийн гадаад харилцааны асуудлууд нь ингээд боогдоод хаагдаад байдаг нэг асуудал байгаа юм.

Тэгэхээр тэр саяын ярьсан жишиг хууль гэдэг юманд нь л бид нар барьчихсан тэрэнд тохирсон тэр шаблонд тохирсон л хууль л боловсруулаад байгаа ухаантай юм.

Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё.

Чинзо гишүүн. Энэ сая л өргөн барьсан шүү дээ. Ерөөсөө сая өргөн бариад үүнийг маш яаралтай бид хэд чинь ажлын хэсэг ажиллаад л тэгээд буцаж оруулж ирж байна шүү дээ. Энэ чинь ерөөсөө 5 сарын 25-нд барьсан өргөн барьсан хууль. 5 сарын 25-нд өргөн барьсан хууль. Засгийн газраас сая 5 сарын 25-нд өргөн баригдсан хууль шүү дээ. Ер нь яах вэ, Засгийн газар л өргөн барьсан хууль. Тэгээд энэ Засгийн газрын өргөн барьсан хуульд Чинзо сайд аа, Засгийн газрын өргөн барьсан хуульд энэ чинь хавсралтын 27 ингэж орж ирсэн юм.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Энэ хар даа. Засгийн газрын өргөн барьсан хууль дотор нислэгийн хөдөлгөөний хяналтын агаарын зай нь нислэгийн аюулгүй байдал конвенцын хавсралтын стандарт журмын шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламжаар тоноглогдсон гэж байгаа юм. Агаарын зай нь байгууламж энэ тоног төхөөрөмжөөр тоноглогдсон гээд ийм ерөөсөө Монголоор бол ойлгохооргүй үг үсэг орж ирчхээд байгаа байхгүй юу даа. Агаарын зай нь тоноглогдоно гэж, тийм.

Тэгэхээр үүнийг ер нь яах вэ, тоног төхөөрөмжийн хүрээнд нь хяналт агаарын зайгаа бид нар хяналт хийнэ ээ гэсэн утгаар төхөөрөмжийг ашиглан хяналттай агаарын зайд нисэхийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ гэж байгаа юм. Ер нь агаарын навигаци гэдэг чинь өөрөө үйлчилгээ үзүүлэх байгууллага шүү дээ, үйлчилгээ үзүүлэх л үйл ажиллагаа.

Энд хар даа, хаана байна. Далай ашиглах хуулийн 37.4-д гэрчилгээний загвар нь далай ашигласан нөгөө өгдөг гэрчилгээнүүд байдаг юм. Тэр гэрчилгээний загвар нь энэ хуулийн 37.1-д заасан конвенцын хавсралтад заасан загвартай ижил байна гэсэн байна. Шаардлагыг хангасан байна гэж байгаа юу.

Чинзориг гишүүний микрофоныг өгье.

**С.Чинзориг:** Дарга цохиж болно шүү дээ. Би тэгж микрофон ажилласангүй гэж хэлж үзээгүй. Үгийн санал алга.

**Ж.Бат-Эрдэнэ:** Чинзориг гишүүн саналын томъёоллыг дахин сонсьё гэсэн учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоё.

Хүчингүй болгох санал хураалт явуулъя. Цуцлах санал хураалт. Санал хураалт.

54,5 хувиар саяын санал цуцлагдлаа, хүчингүй боллоо.

Санал хураалт, санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. 26.25 дугаар саналыг дахин санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

26. төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Би энэ төслийн 26 дахь юу, ажлын хэсгийн 26 дахь санал буюу төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг хасах саналыг дэмжихгүй үг хэлэх гэж байгаа юм. Энэ төсөлтэй байх ёстой заалт байна. 28.2 нь ямар заалт байна вэ гэхээр агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогоос жил бүрийн Төсвийн тухай хуульд заасан дүнгээр хуульд заасан хугацаанд улсын төсөвт төвлөрүүлнэ ээ гэдэг заалт байгаа юм. Үүнийг хасчихаар агаарын навигацийн орлогыг ерөөсөө улсын төсөвт төвлөрүүлэхгүй юм шиг болчихоод байна шүү дээ. ИНЕГ чинь өөрсдөө мэдэхээр л. Тэгтэл миний хэлэлцэх эсэхийг шийдэх үед Засгийн газраас асууж байснаар бол иргэний нисэхийн жилийн орлого чинь хамгийн оргил үедээ буюу 19 онд 400 тэрбум гэл үү, 400 тэрбум хүрч байсан гэж байна лээ шүү дээ. Тэгэхээр чинь энэ чинь ийм манайх одоо яах вэ, энэ мэдээж гадаад геополитик, дайн тулааны нөхцөл байдал дуусаж л таарах байх. Тийм, байнга иймээр байхгүй шүү дээ. Энэ дайн дуусаж л таарна шүү дээ, эхэлсэн шигээ л дуусна. Тэгээд иргэний нисэхийн орлого цаашидаа өсөн нэмэгдэж таарна. Мөн тэр 19 оныхоо хэмжээнд орлого орчих нөхцөл байдал ойрын үед бий болох байлгүй дээ. Тэгээд тэр үедээ энэ чинь улсын төсөв рүү орохгүй ингээд иргэний нисэх өөрөө бүх орлогоо зарцуулаад байна гэвэл Улсын Их Хурал бол Монголын нийт ард түмний төлөөлөл бөгөөд улсын төсвийн бодлогыг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

татварын бодлогыг тодорхойлох чинь бол Улсын Их Хурал байгаа. Тэгээд улсын төсөвт оруулахгүй гэдэг бол ард түмний төлөөллийн дээд байгууллагынх нь хараа хяналтаас ийм хэмжээний мөнгийг хяналтыг нь гаргаад явчхаж байна гэсэн үг шүү дээ. Тийм учраас би үүнийг зөвшөөрөмгүй байна.

Бид нар төрийн өмчит компаниудын орлого Улсын Их Хуралдаа хянагддаг байх ёстой гэдэг асуудал яриад байгаа шүү дээ. Түүнээс чинь болоод л энэ Эрдэнэс тавантолгой тойрсон нүүрсний асуудал чинь хэдэн их наядаар хулгай зэлгий болчихсон асуудлыг бид араас нь яриад байгаа шүү дээ. Ерөөсөө Их Хурлаар ордоггүй. Монгол Улсын Их Хурал чинь жилдээ 300 тэрбумын шинээр хөрөнгө оруулалтын юм яриад байгаа байхгүй юу. Тэгэхэд тэнд нэг төрийн өмчийн компанийн захирал хэдэн их наяд төгрөг 10 их наядын мөнгө нэг гүйцэтгэх захирал чинь шийдчихсэн байна шүү дээ. Тэгэхээр энэ иргэний нисэхийн орлого хураамжийг хэрхэн яах вэ гэдэг асуудал бол нийт ард түмний төлөөллийн дээд байгууллагын хараа хяналтаас гаргаж болохгүй гэж би бодож байна. Тийм учраас би энэ 28.2 дахь саналыг хасах саналыг дэмжихгүй санал, үг хэлж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ ийм байгаа юм. 28.2 агаарын навигацийн үйл ажиллагааны орлогоо жил бүрийн улсын төсвийн тухай хуульд заасан дүнгээр хуульд заасан хугацаанд улсын төсөвт төвлөрүүлнэ ээ гээд ийм заалт байгаа юм. Тэгэхээр ийм. Ер нь экаус тавьж байгаа шаардлагын хүрээнд агаарын навигациас олж байгаа орлогыг яг үйл ажиллагаандаа зарцуулна гэсэн ийм шаардлагыг л тавьдаг юм. Бид болохоор үүнийгээ улсын төсөвт ингээд өгч байгаа гэсэн ийм хуульд хийчихээр та нар өөрсдөдөө хөрөнгө оруулалт хийж, апдэйт хийж, ингээд бүх хяналтыгаа аюулгүй байдлын бүхий л хяналтдаа хөрөнгө оруулалтаа хийхгүйгээр энэ хөрөнгө оруулалт байсан хийх ёстой

байсан зүйлээ улсын төсөвтөө өгчихлөө тэгээд одоо шаардлагын дагуу, стандартын дагуу тодорхой хөрөнгө оруулалтууд, тодорхой үйл ажиллагаа явуулах боломж бололцоогоо алдаад байна гэсэн ийм юуг л сануулгыг л дандаа тавьдаг юм л даа. Энэ ерөөсөө энэ экаугийн шалгалтад өртөөд байдаг гохдогдоод байдаг бас асуулт байгаад байгаа юм.

Тэгэхээр үүнийг бид нар Төсвийн тухай хуульдаа оруулаад явахад өгөхгүй гэх зүйл байхгүй шүү. Өгч болохгүй гэсэн заалт биш. Тийм болохоор Төсвийн тухай хуулиараа энд чинь заалт байж байгаа шүү дээ. Жишээ нь, Төсвийн тухай хуульд заасан дүнгээр хуульд заасан хугацаанд эд нар гээд бид нар Төсвийн тухай хуулиа жил болгон Улсын Их Хурлаараа батлахдаа л жишээ нь иргэний агаарын тээврийн навигацийн орлогоос тэдэн төгрөг гэдэг ч юм уу энийгээ хэдүүлээ батлаад явчихад болохгүй гэх зүйл байхгүй юм л гэж үзсэн юм.

Яг энэ үг үсгээрээ болохоор ерөөсөө орлогоо тийшээгээ өгчих гээд байгаа юм шиг харагдах гээд байгаа юм л даа.

Санал хураалт.

Төсвийн хуулиар зохицуулаад явчхаж бас болно л доо, уг нь бол.

36,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

27. Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “төрийн өмчит” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 33.3 дахь хэсэг нэмэх:

“33.3.Олон улсын нисэх буудал дахь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

28. Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын “аэродромд нисгэх” гэснийг “аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн” гэж өөрчилж, 34.1.2 дахь заалтын “өндөржүүлсэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

29. Төслийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “хяналтын” гэснийг “хяналт тавих мэргэжлийн” гэж, “7-гоос” гэснийг “таваас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

30. Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “анхан шатны мэдээллийг нэн даруй, боломжит хэлбэрээр өгөх, дэлгэрэнгүй мэдээллийг” гэснийг “анхан шатны болон дэлгэрэнгүй мэдээллийг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад” гэж өөрчилж, 39.3 дахь хэсгийн “эзэмшигч” гэсний өмнө “өмчлөгч” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

31. Төслийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

32. Төслийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “шалгагч шинжлэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

34. Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийг доор дурдсанаа өөрчлөн найруулах 51.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг.

33. төслийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

34. Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“51.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”  
Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

35. Төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр, томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3 дахь заалтын “, эсхүл” гэснийг “болон” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “төрийн бодлого” гэснийг “талаар төрөөс баримтлах бодлого” гэж, 8.1.9, 8.1.10 дахь заалтын “албаны” гэснийг “байгууллагын” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “Конвенц, түүний” гэснийг “Конвенцын” гэж, 9.2.2 дахь заалтын “тохирогч” гэснийг “тохиролцогч” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь хэсгийн “нөлөөлөхүйц” гэснийг “нөлөөлж болзошгүй” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “үзлэг” гэснийг “хяналт” гэж, “иргэний нисэхийн мэргэшсэн” гэснийг “нисэхийн гэрчилгээжсэн” гэж, 11.3 дахь хэсгийн “шилжүүлэн гүйцэтгүүлэх” гэснийг “шилжүүлэх” гэж, 12.1.8 дахь заалтын “эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт” гэснийг

“эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.9 дэх заалтын “хамгаалалтын хөтөлбөр” гэснийг “хамгаалалт” гэж, 12.1.12 дахь заалтын “ажиллагааны гэрчилгээжүүлэлт” гэснийг “ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.13 дахь заалтын “болон аэродромын үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт” гэснийг “, аэродромыг гэрчилгээжүүлэх” гэж, 12.1.10, 12.1.14, 12.1.15, 12.1.16, 12.1.18 дахь заалтын “байгууллагын гэрчилгээжүүлэлт” гэснийг “байгууллагыг гэрчилгээжүүлэх” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын “үр шим” гэснийг “үр ашиг” гэж, 16.1.2 дахь заалтын “ажил гэдэгт” гэснийг “ажилд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь” гэснийг “Агаарын тээвэрлэгч” гэж, “гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээ бүхий” гэснийг “гүйцэтгэх шаардлага хангасан” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “нислэгийн” гэснийг “нисэхийн” гэж, 20.5 дахь хэсгийн “дүрмээс гадуур” гэснийг “дүрэмд зааснаас бусад” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.8 дахь заалтын “нисгэх” гэснийг “агаарын хөлгийн” гэж, 19.3.2 дахь заалтын “өөрөөр шийдвэрлэх” гэснийг “нислэгийг хэвийн үргэлжлүүлэх” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “нислэгийн” гэснийг “нисэхийн гэж, 20.5 дахь хэсгийн “дүрмээс гадуур” гэснийг “дүрэмд зааснаас бусад” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “зорчигчийг аюулгүй болгох” гэснийг “зорчигчид шаардлага тавьж, аюулгүй байдлыг хангах” гэж, 21.4 дэх хэсгийн “учруулахуйц” гэснийг “учруулж болзошгүй,” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтын “гэрчилгээ нь хүчингүй болсон” гэснийг “гэрчилгээгүй” гэж, “зөрчсөн” гэснийг “зөрчиж” гэж, 22.1.6 дахь заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж, 22.1.7 дахь заалтын “нисгэх” гэснийг “нисэх” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “нэвтрэн өнгөрөх” гэснийг “нэвтрэх” гэж, 23.2 дахь хэсгийн “Нислэгийн хөдөлгөөний” гэснийг “Агаарын

навигацийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэрт” гэснийг “нутаг дэвсгэр, агаарын зайд” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “зайн” гэснийг “зайд” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “байгуулна” гэснийг “байгуулж болно” гэж, 29.3 дахь хэсгийн “аэродром нь” гэснийг “аэродромын үйл ажиллагаа эрхлэгч” гэж, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн “хууль, дүрмийг” гэснийг “хууль тогтоомж, иргэний нисэхийн дүрмийг” гэж, 33.4 дэх хэсгийн “хураан авах, эсхүл саатуулна” гэснийг “хураан авна” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “мэргэшсэн” гэснийг “гэрчилгээжсэн” гэж, “гэрчилгээжүүлэлт” гэснийг “гэрчилгээ” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.3 дахь заалтын “үзлэг” гэснийг “хяналт” гэж, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “нислэг техникийн” гэснийг “агаарын хөлгийн” гэж, 42 дугаар зүйлийн 42.4.6 дахь заалтын “албаны” гэснийг “байгууллагын” гэж, 45 дугаар зүйлийн 45.1, 45.2 дахь хэсгийн “алба” гэснийг “байгууллага” гэж тус тус, “төрийн захиргааны байгууллага” гэснийг “иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тохиолдол бүрд өөрчилж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “үйлдэж байгаа” гэснийг дараах “улсын агаарын хөлгийн” гэснийг мөн заалтын “бусад” гэснийг дараа шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “, тэдгээрийг багтаасан” гэснийг, 5.1.7 дахь заалтын “эсхүл” гэснийг, 5.1.8 дахь заалтын “Чикагогийн” гэснийг, 5.1.10 дахь заалтын “, түүний” гэснийг, 5.1.13 дахь заалтын “төлөв” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “үйл” гэснийг, 9.2.5 дахь заалтын “иргэний” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “эсхүл” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “агаарын хөлөг үйлдвэрлэгчийн” гэснийг,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “нислэгийн үйл ажиллагаанд” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “агаарын хөлөг” гэснийг, 23.2 дахь хэсгийн “нисгэх” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “дарга, нисгэх” гэснийг, 43 дугаар зүйлийн 43.2.1, 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “ямар ч үед” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 9 дүгээр зүйлийн “хэлэлцэн” гэсний өмнө “Конвенцын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтын “Дарга” гэсний дараа “энэ хуулийн 11.1-д заасан” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “зохицуулалт” гэсний дараа “хийх” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “гэрчилгээ” гэсний өмнө “агаарын тээвэрлэгчийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “Нислэгийн” гэсний дараа “үед” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “багийн” гэсний өмнө “агаарын хөлгийн” гэж, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “зориулсан” гэсний дараах “аэродромын” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэсний дараа “цаашид “Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага” гэх/” гэж, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хамгаалалтын” гэсний дараа “үйлчилгээний” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “нислэгт” гэсний өмнө “агаарын хөлгийн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “4 дүгээр зүйлийн” гэсний дараа “4.1.1 дэх заалтын “дээшхи хийн мандлын агаарын

давхрагын” гэснийг “дээших агаар мандлын” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

2 дугаар асуулт.

Энэ дээр Байнгын хорооны хурлын тэмдэглэлд үлдээх санал байгаа. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд Иргэний нисэхийн тухай хуулийн төслийн холбогдох заалт, эшлэлийг заалтуудыг эшилсэн.

Ингээд Иргэний нисэхийн тухай хууль төсөлд ажлын хэсэг гишүүдээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг дэмжсэн тэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт өөрчлөгдөж байгаа тул хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх саналыг бэлтгэн оруулах шаардлагатайг сануулж хэлж байна.

Ингээд хуулийн төслүүдийг зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Дараагийн асуудал. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагчийн хувиар би уншиж танилцуулъя. Ажлын хэсэгт баярлалаа.

2 дугаар асуудал.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 2 дахь асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1 дэх хэсэгт заасныг баримтлан өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

Ингээд Монгол Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэлийн хүсэлтийг үндэслэн Ковидын төсвийн асуудал гэсэн байгаа байх аа. Алив.

16.48 цаг

**“Коронавируст халдварын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн зарцуулалт, гадаадын орнуудаас авсан зээл, тусламж, дотоодын иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж, тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Ингээд Цогтгэрэл гишүүн хүсэлтээ танилцуулъя. Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

**О.Цогтгэрэл:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Коронавируст халдварын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаад орнуудаас авсан зээл, тусламж, дотоодын иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох шаардлагатай гэж үзэж байгаа билээ.

Иймд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.12, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3, Монгол

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ерөнхий хяналтын сонсгол явуулах нь зүйтэй гэж үзсэн тул зохих хууль журмын дагуу шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Саналтай холбоотой асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хугацаа л ярьж болно, одоо, тийм. Энэ Чинзориг энэ коронавирусийн халдварын үед цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн асуудлаар гэж байгаа юм. Ерөнхий хяналтын сонсгол, тийм. Хугацаа болон энэ тогтоолын төсөлтэй холбоотой санал хэлэх гишүүд байна уу? Хугацаатай холбоотой болон бусад асуудлаар. Энхбаяр. Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Би Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг буюу цөөнхийн бүлгээс гаргаж байгаа ковидын үеийн төсвөөр хяналтын ерөнхий сонсгол хийх саналыг дэмжиж байна.

Тэгэхдээ энэ хаврын чуулганаар хийх хэрэггүй, тийм, намар хийх хэрэгтэй. Үүнийг нэлээн бэлтгэл ажлыг нь хангаж байгаад, найр наадмын цагаар хийсэн нэр зүүсэн болж хийх нь буруу. Тийм учраас энэ асуудлыг одоо шийднэ. Тэгэхдээ намрын чуулганаар хийх нь зүйтэй гэсэн ийм саналтай байна. Өдрийн хувьд тэгээд Ардчилсан намын бүлэг өөрөө өдрөө саналаа гаргах хэрэгтэй л дээ. Хэдийд хиймээр байгаа юм, тийм ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ эсвэл намрын чуулганаар нэгмөсөн оруулах юм уу. Цогтгэрэл гишүүний микрофон өгье.

**О.Цогтгэрэл:** Яг дэгийн тухай хуулиар, манайхан байж байгаарай. Дэгийн тухай хуулиар товлон зарлах, дахиад дээрээс нь үүнээс ажлын хэсэг гаргах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тогтоох, ажлын хэсгийн даргыг тогтох гээд дэгийн тухай хуулиар эдгээр зүйлүүдийг шийдэх ёстой юм байна лээ. Тэгэхээр бэлтгэл ажил хангахын тулд бид нар бас ингээд чуулган завсарлаж байгаа болохоор өдөр дээр болохоор 1 дэх, 2 дахь өдрийг тааруулаад 2023 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд 2 өдөр хийе гэдэг саналыг гаргаж байгаа юм. 10 дугаар сарын 23, 24, 10 сарын 05-нд чуулган эхлэх юм байна лээ. Тийм. Төсвийн үеэр дундуур нь төсвийн эхний хэлэлцүүлэг яваад дууссаны дараа тэр үеэр бас бэлтгэл ажил 23, 24-ний өдрүүдэд, тийм.

Тэгэхээр Байнгын хорооноос товлон зарлаж өгөх, дахиад дээрээс нь ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажлын хэсэг гарах юм байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг, мөн ажлын хэсгийн даргыг томилж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Дэгээрээ бас үүнийг, үгүй ээ яах вэ, яг.

Тэгэхдээ Бат-Эрдэнэ дарга аа, Их Хурлын даргатай, бас олонхын бүлгийн даргатай саяын бүрэлдэхүүнийг ер нь ингээд яриад зөвшилцчихсэн бүрэлдэхүүн байгаа. Би бас санал болгох гээд байна л даа. Одоо санал болгох уу, саяынхаар саналаа хураах юм уу. Эхлээд байгуулна гэдгээ хураачихсан нь дээр байх. Байгуулна гэдгээ хураачхаад дараа нь тэр дэгийн болоод товлох зүйлүүдийг тусад нь хураасан нь дээр байх. Эхлээд ер нь энэ ерөнхий хяналтын сонсголыг явуулах нь зүйтэй гэдгийг эхлээд хураах байхдаа бодвол. Тус бүрд нь хураах байх. Дараа нь өдрийг хураачих байх. Дараа нь бүрэлдэхүүнийг.

**Ж.Бат-Эрдэнэ:** Эхлээд ажлын хэсэг одоо энэ чинь ажлын хэсэг байгуулах гэж байгаа шүү дээ, тийм үү? Таны саналаар болбол. Үгүй ээ, эхлээд ерөнхий сонсгол байгуулах ажлын хэсгийг байгуулах юм шүү дээ. Бэлтгэл хангах ажлын хэсэг байхгүй юу. Ерөөсөө ерөнхий сонсгол бэлдэх ажлын хэсгийг одоо байгуулчихаад тэгээд сүүлд нь ажлын

хэсэг чинь танилцуулж байгаад дахиад ерөнхий сонсгол нь хэзээ байх вэ эд нар гэсэн, тийм.

Ажлын хэсэг байгуулаад ажлын хэсэг чинь өөрөө бас тодорхой хэмжээний, сая нүүрсээр чинь ажлын хэсэг байгууллаа шүү дээ. Тэгээд ажлын хэсэг чинь сонсгол явуулах ажлын хэсэг чинь өөрөө тийм тийм тийм учиртай, ийм юм үндэслэлээр гээд, тийм. Одоо ажлын хэсгээ л байгуулчихъя.

Ажлын хэсэг байгуулъя гэдэг дээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Тийм болохоор ажлын хэсэг байгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та санал гаргах уу? Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

**О.Цогтгэрэл:** Гжлын хэсгийн бүрэлдэхүүнийг бас зөвшилцсөн. Тэгээд үүн дээр ажлын хэсгийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байя гэж зөвшилцсөн. 1 дүгээрт нь, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, 2 дугаарт нь Улсын Их Хурлын гишүүн Батсуурь, 3 дугаарт нь Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр, 4 дүгээрт нь Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, 5 дугаарт нь Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар гэсэн ийм 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулъя гэдэг саналыг гаргаж байгаа юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Үгүй ээ, одоо наадхыг чинь батална биз дээ? Чинзо.

Ийм саналыг оруулж байна. Цогтгэрэл гишүүн, Батсуурь гишүүн, Баттөмөр гишүүн, Тэмүүлэн, Оюунчимэг гэсэн. Оюунчимэг гишүүнийг оруулчихъя. Оюунчимэг гишүүн гээд ингээд 5 хүний.

Ийм байна. Даргалагчийн хувиар энд нэг нэр оруулаад тэгээд санал оруулаадахъя. Цогтгэрэл, Батсуурь,



2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Баттөмөр, Тэмүүлэн, Оюунчимэг гэсэн. Оюунчимэг гишүүн ингээд 5 гишүүн, болж байна уу.

Энхбаяр гишүүн хэрэггүй байх. Одоо бүх л зүйл дээр орж ирлээ. Үгүй ээ, үгүй ерөөсөө энэ Төсвийн байнгын хороо гэдгээрээ энэ чинь Тэмүүлэн орсон нь дээр байхгүй юу. Тэгээд саяынхаар санал хураачихъя. Цогтгэрэл гишүүн, Батсуурь гишүүн, Баттөмөр, Тэмүүлэн, Оюунчимэг гэсэн. Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ажлын хэсгийн ахлагчийг угаасаа байнгын хороонд тогтоолоорой ажлын хэсгийн ахлагчаар Цогтгэрэл гишүүнийг санаачилга гаргасан гээд тавьчихъя, тэгэх үү? Санал хураалт.

54,5 хувиар санал дэмжигдлээ.

Үгүй ээ, зүгээр та нар өөрсдөө ажлын хэсэг чинь санал оруулж ирнэ шүү дээ. Тэгчхээд дахиждахиж юу яах байхгүй юу. Тийм. Үгүй ээ, үгүй, үгүй ээ буцаад орж ирээд ажлын хэсэг чинь орж ирээд танилцуулаад, тэгээд юу яана шүү дээ.

Ингээд 10-наас хэд байна. Цаг хугацаагаа хараадах даа.

Үгүй, үгүй, үгүй. Сонсгол даргалагч эд нар, сонсгол чинь сүүлийн асуудал, дараагийн асуудал байхгүй юу. Тэгэхээр рдрр буцааж танилцуулах тийм үү. Ажлын хэсэг буцааж орж ирж байж танилцуулна шүү дээ. Тэгж байж сонсгол явуулах өдрөө тохирно шүү дээ.

Намрын чуулган эхлээд тэгээд ажлын хэсэг орж ирээд юугаа танилцуулчих л даа. Намрын чуулган эхлүүлээд. Одоо жишээ нь.

Нээлттэй сонсгол явуулах өдрийг тогтох гэж байна, тийм үү. Нээлттэй сонсгол явуулах хугацааг 2023 оны 10 сарын 23, 24 гэж байна уу.

Байнгын хорооны тогтоол. Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1, 119 дүгээр зүйлийн 119.1, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

Коронавируст халдварын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаадын орнуудаас авсан зээл, тусламж, дотоодын иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох санхүүжилтийн асуудлаар ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Тэгээд түрүүний 5 нэр байгаа.

2. Ерөнхий хяналтын сонсголын даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл. Цогтгэрэл тийм ээ.

3. Дээрх асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагын тайлан мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсгол явуулах өдрийг 2023 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрийн 10 цагт товлосугай.

Цагийг нь заах юм уу, тийм ээ, товлосугай.

4. Сонсгол зохион байгуулалт, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Цогтгэрэл, Улсын Их Хурлын Тамгын газар Өлзийсайханд тус тус даалгасугай.

Ингээд санал хураачих уу. Санал хураалт.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

*Тогтоолыг баталъя гэдэг  
томъёоллоор санал хураалт.*

*54,5 хувиар тогтоолын төсөл  
батлагдлаа.*

*Өнөөдрийн Эдийн засгийн байнгын  
хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал  
дууссан тул хуралдаан өнгөрснийг  
мэдэгдье.*

*17.07 цаг*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*П.ОЮУНГЭРЭЛ*